



**ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 40 ДУГААР  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 41

Мөрөн сум

**Хоршоог хөгжүүлэх сангийн  
тэргүүлэх чиглэл батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48,1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.3, 3.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, төсөл хөтөлбөртэй уялдуулан хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох зорилготой "Хоршоо хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл"-ийг хавсралтаар баталсугай.

2. Хоршоо хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийг иргэд олон нийтэд сурталчилан танилцуулах, энэхүү чиглэлийг баримтлан төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг Хорооны гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА *Ж.Дашжамц* Ж.ДАШЖАМЦ



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн  
..А. дугаар тогтоолын хавсралт



Хоршоо хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл

Д/д	Чиглэл	Үйл ажиллагаа
1.	Үйлдвэрлэлийн чиглэлээр	Мод, модон эдлэл
		Гар урлал, бэлэг дурсгалын үйлдвэрлэл
		Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл
		Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
		Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
		Барилгын материалын үйлдвэрлэл
		Арьс шир боловсруулах үйлдвэрлэл
		Сур суран эдлэл
		Төмөр, төмөр хийц
		Мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн
2.	Үйлчилгээний чиглэлээр	Аялал жуулчлалын үйл ажиллагаа
		Гуталчин, үсчин, гоо сайхан ч, засварчин
		Фото зураг, хэвлэлийн үйлчилгээ
		Авто засвар үйлчилгээ /авто засвар, угаалга/
		Жижиглэн худалдааны лангуу /зам дагуу/
3.	Хөдөө аж ахуйн чиглэлээр	Хүнсний ногоо тариалах, зoorь агуулахын үйл ажиллагаа
		Эрчимжүүлсэн мал, мал аж ахуй, туслах аж ахуй
		Мал нядалгааны цэг / хөргүүр, хөлдөөгч мал нядлах, мах шулах, мах эвдэх, дотор цэвэрлэх/
		Орон нутгийн онцлогт тохирсон нутгийн бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэл
		Хөдөө аж ахуйн үйлдвэр тариалалт /малын тэжээл бэлтгэх, бутлах, савлах тоног төхөөрөмж/

